

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЗАНГИЛАА АСУУДЛУУДЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа

Нэг. Макро эдийн засгийн үндсэн /зангилаа/ асуудлууд, төрийн зохицуулалт:

Онопын хувьд макро эдийн засгийн зангилаа асуудлуудыг дараах асуудлуудын хүрээнд авч үзсэн бөгөөд төрөөс эдгээр асуудлуудыг зохицуулж, зохистой байдлыг хангахад түлхүү анхаардаг байна. Үүнд:

- Ажил эрхлэлтийг дэмжих;
- Инфляцийг зохистой түвшинд хязгаарлан барих;
- Эдийн засгийн мөчлөгийг тогтвортжуулах;
- Улсын төсвийн алдагдлыг бууруулах;
- Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах

Эдгээр эдийн засгийн зорилтуудыг хангахын тулд төрийн зүгээс сангийн болон мөнгөний бодлогын арга хэрэгслээр дамжуулан төрийн зохицуулалт хийж тодорхой арга хэмжээ авдаг.

Макро эдийн засгийн үндсэн зорилгууд болох урт хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох, инфляцийг тогтвортжуулах болон ажилгүйдлийг бууруулах зэрэг эдийн засгийн хөгжлийн тулгуур асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн төрийн үйл ажиллагааг **сангийн бодлого** гэж ойлгож болно. Тодорхойлолтоос харахад татварын болон төсвийн зарлагын өөрчлөлт гэсэн параметрүүд нь сангийн бодлогын үндсэн арга хэрэгслүүд болдог. Иймд сангийн бодлогыг явуулахдаа эдгээр арга хэрэгслүүдийг хослуулах, угсуулах зэргээр төр эдийн засгийн төлөв байдалдаа нөлөөлөх боломжтой. Гэхдээ сангийн ямар бодлого явуулах нь эдийн засгийн тухайн үеийн төлөв байдлаас шалтгаална.

Сангийн бодлоготой ижил зорилготой боловч мөнгөний нийлүүлэлт, хүү зээлийн нөхцлийн өөрчлөлтөөр дамжин хэрэгждэг бодлогыг төрийн мөнгө-зээлийн бодлого гэж нэрлэдэг.

Мөнгөний нийлүүлэлт-зээл гэсэн параметрүүд нь мөнгө зээлийн бодлогын үндсэн арга хэрэгслүүд болдог байна. Үндсэн параметрүүдийг хэрхэн өөрчлөх нь эдийн засгийн тухайн үеийн нөхцөл байдлаас хамаарна. Тухайлбал, эдийн засгийн уналтын үед мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэн, зээлийн хүүг бууруулдаг байхад, хэт халалтын үед эсрэгээр гүйлгээн дэх мөнгөний тоо хэмжээг багасгаж, харин зээлийн хүүг өсгөдөг. Эдгээр арга хэмжээний үр дүнд эдийн засаг ерөнхий хандлагынхaa дагуу өсөх боломжтой болдгийн зэрэгцээгээр үнийн ерөнхий түвшин тогтвортжог байна.

Манай улсын макро эдийн засгийн үндсэн /зангилаа/ асуудлуудын өнөөгийн төлөв байдлын талаарх тоон мэдээллийг Үндсэний Статистикийн Хорооны www.nso.mn, www.1212.mn сайтнаас авч ашигласан болно.


Хоёр. Макро эдийн засгийн өнөөгийн төлөв байдал

2014 оны эхний хагас жилийн байдлаар манай улсын макро эдийн засгийн үзүүлэлтүүд, төлбөрийн тэнцэл, төсвийн алдагдал, инфляци, валютын ханш зэрэг нь өмнөх онуудад байгаагүйгээр өндөр үзүүлэлттэй гарсан.

Энэ нь 2012 оноос эхлэн эдийн засгийн нөхцөл байдал хүндэрсэн, эдийн засгийн мөчлөн дагасан төсвийн бодлого, ирээдүйд олох экспортын бүтээгдэхүүн /уул уурхайн орлого/-ийг барыцаалж авсан богино хугацаатай зээлээр санхүүжсэн нийгмийн хавтгайрсан хalamж буюу бэлэн мөнгө тараалт, гадаад секторын эрсдэлд өртөмтгий байдал, эдийн засгийн хувьд эрдэс баялгийн салбараас хэт хараат байдал зэрэгээс шалтгаалсан байна.


Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн өнөөгийн нөхцөл байдлыг зургаар авч үзвэл:

Зураг 1. ДНБ-ний өсөлт, бууралт (%) (улирлын нөлөөллийг арилгасан)




Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2011 онд 17.5 хувь хүрч байсан бол энэ өсөлт жил, улирал, сар дараалан буурсаар 2012 онд 12.3 хувь, 2013 онд 11.7 хувь, энэ онд 9 орчим хувь байхаар байна. Монгол Улсын инфляциын түвшин сүүлийн 3 жил дараалан 2-оос дээш оронтой тоогоор илэрхийлэгдэж энэ үзүүлэлтээрээ дэлхийд эхний арванхоёрдугаарт бичигдэж байна. Иргэдийн өдөр тутмын амьдралдаа хэрэглэдэг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өнгөрсөн 2 жилийн хугацаанд 10.6 хувиас 177 хувь хүртэл өсч, инфляцийн өсөлт иргэдийн амьжиргаанд хүчтэй дарамт үзүүлж нийгэмд сөрөг үзэгдэл үзүүлж байна.

Зураг 2. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, өссөн дүнгээр (сая.төг)




Зураг 3. Инфляцийн түвшин, оны эхнээс (%)



Амдолларын ханшийн өсөлт үргэжилсээр байна. Амдолларын ханш 2012 оны 7 дугаар сард 1349 төгрөгтэй тэнцэж байсан бол өнөөдрийн байдлаар төгрөгийн амдоллартай харьцах ханш 1844 төгрөг болж 38 хувиар уналаа. Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн ханш ийнхүү огцом суларч байгаа нь иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хүнд дарамт учруулж байна.


Монгол Улсын гадаад валютын албан нөөц өнгөрсөн зургадугаар сарын байдлаар 1.31 тэрбум амдоллар болж буурсныг Төвбанк мэдээлсэн. Энэ нь өмнөх сарынхаас 17.9, өнгөрсөн оны мөн үеэс 57.6 хувиар доошилж, 2012 оны 7 дугаар сард байсан 2.8 тэрбум амдолларын нөөц 2.2 дахин багассан үзүүлэлт юм.

Зураг 4. Гадаад худалдааны нийт тэнцэл, өссөн дүнгээр (сая. амдоллар)



Банк санхүүгийн салбарт ч өндөр эрсдэл бий болсныг Үндэсний статистикийн хорооноос гаргасан тайлангаас харж болно. Банкны системийн хэмжээгээр чанааргүй зээлийн хэмжээ 7 дугаар сарын эцэст 599.7 тэрбум төгрөг, хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 550.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 32.4 хувиар, хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 3.4 дахин өссөн үзүүлэлтэй гарч, нийт банкны систем дэх эрсдэл эрсдэл нэмэгдсэн байна.

Зураг 5. Ажилгүйдлийн түвшин, улирлаар (%)



Энэ оны 7 дугаар сарын байдлаар Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийн 54.3 хувь нь буюу 54.8 мянган аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа зогсоосон нь 2012 оны мөн үетэй харьцуулахад 84.5 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь манай улсын бизнесийн орчин муудсаны илэрхийлэл юм.

Гурав. Эдийн засгийн салбарын эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал

1. “Төсвийн тогтвортой байдлын тухай” хуулийн хувьд:

- Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хувьд Төсвийн орлогын төлөвлөлтөнд уул уурхайн бүтээгдэхүүний үнийн хэлбэлзлийн нэлөөллийг бууруулах үүднээс тэнцвэржүүлсэн үнээр тооцдог болсон хэдий ч биет хэмжээгээний өөрчлөлт томоохон эрсдэл учруулж байна. Иймээс төсвийн орлогын төлөвлөлтөнд эрсдлийг индексжүүлж тооцох, зардлын төлөвлөгөөг орлогын төлөвлөгөөнөөс шууд хамааруулан тооцдог болох шаардлагатай байна.
- Төсвийн Тогтвортой байдлын хуулийн 6.1.3-т “Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялагийн бус ДНБ- өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялагийн бус ДНБ-ий өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх” гэж заасан. Гэвч хуулийн заалт нь төсвийн зарлагын өсөлтийн хязгаарлахад бодит үр дүн үзүүлж чадахгүй байна. Төсвийн орлогын өсөлтийг дагасан төсвийн зарлагын хэт өсөлтийг хязгаарлах, түүхий эдийн экспортоос хамааралтай төсвийн орлогын хэлбэлзлийг бууруулах, улмаар үндэсний санхүүгийн хуримтлал бүрдүүлэх зорилгоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуулинд “Төсвийн тусгай шаардлага”-ыг тодорхойлж өгсөн. Үүний дагуу тухайн жилийн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялагийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялагийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх ёстой.
- Мөн хуулийн 6.1.1-т “ул уурхайн салбарын гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн дүрмийн санд хувь оруулах зориулалттай бөгөөд тухайн хуулийн этгээдийн ирээдүйн ашгаас эргэн төлөгдөх нөхцөлтэй байгуулсан гэрээний дагуу авсан Засгийн газрын зээл, эсхүл гэрээний энэхүү нөхцөлөөр гаргасан Засгийн газрын баталгааг хамааруулахгүйгээр тооцсон улсын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 40 хувиас хэтрэхгүй байх” гэж заасан. Үүнд “улсын өр” гэж Засгийн газрын дотоод, гадаад зээл, санхүүгийн түрээс, Засгийн газраас гаргасан баталгаа, өрийн бичиг, төрийн болон орон нутгийн өмчт болон тэдгээр өмч давамгайлсан хуулийн этгээдийн ирээдүйд эргэн төлөх үүрэг хүлээсэн санхүүгийн бүх төрлийн төлбөрийн үүргийн мөнгөн дүн, түүнд ногдох хугацаа хэтэрсэн хүү, алданги, торгуулийн нийлбэрийг ойлгоно гэж заажээ. Засгийн газар сүүлийн жилүүдэд хөнгөлттэй нөхцөлтэй зээлийн багцыг удирдан ашиглаж ирсэн төдийгүй эдийн засгийн хурдацтай өсөлтийн улмаас Монгол Улсын зээлжих эрх нэмэгдэж өнөөгийн байдлаар манай улсын нийт гадаад өрийн хэмжээ 2013 оны 3-р улирлын байдлаар 18,199,703 мянган ам.доллар хүрч өмнөх улирлаас 4 хувь, өмнөх оны мөн үеэс 39 хувиар өссөн дүнтэй байна. Үнээс компани хоорондын зээллэг 56.1 хувь, засгийн газрын өр 23.3 хувь, Төв банк 4.9 хувь, арилжааны банкууд 6 хувь, бусад сектор 9.1 хувь эзэлж байна.⁸¹

2. Татварын хууль тогтоомжийн хувьд:

- Татварын хууль эрх зүйн орчинд өөрчлөлт орох, татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой хууль, тогтоомж батлагдан гарах нь төсвийн орлого буурах, төсвийн зарлагад нэлөөлөх үр дагавар бүхий хууль, эрх зүйн орчны аливаа өөрчлөлт, мөн төсвийн зарлагын норм, нормативыг өөрчлөх, орон тоо нэмэгдүүлэх шийдвэрүүд нь 2014 онд төсвийн суурь зарлагыг нэмэгдүүлэх эрсдэлийг бий болгосон. Мөн хууль эрх зүйн орчин тодорхой бус, өөрчлөлт орох хүлээлт бий болох нь хөрөнгө оруулагчдын шийдвэрт нэлөөлж, улмаар гадаадын хөрөнгө оруулалт буурах,

⁸¹Үндэсний статистикийн хороо, Монголбанк.

үүнийг дагаад бүтээн байгуулалт, импорт багасч эдийн засагт сөргөөр нөлөөлсөөс үүдэх улс төр, хууль эрх зүйн орчны эрдэл үүсч болзошгүй байна. /Эдийн засгийн өршөөлийн тухай хууль, Татварын өршөөл үзүүлэх тухай гэх мэт/

3. Төсөв, мөнгөний бодлогын тухайд:

- Төсөв, мөнгөний бодлого хоорондын уялдааны хувьд хангалтгүй. Макро эдийн засгийн түвшинд төрийн гол зохицуулалт болохын хувьд эдгээр хоёр бодлого хоорондын уялдаа чухал байдаг хэдий ч өнөөгийн байдлаар эдгээр бодлогууд нь нэлээн тэлэлттэй байна. Эдийн засгийн халалт үүсгэж, улмаар тогтвортгүй байдал бий болсон нь макро эдийн засгийн бодлогуудын хоорондын уялдаагүй байгааг харуулж байна. Төсөв, мөнгөний бодлогын хэт тэлэлт нь эдийн засаг дах нийт эрэлтийг өсгөж, улмаар инфляцийг онилоод байгаа мөнгөний бодлогын нөлөөг супруулах, инфляцийн түвшинг өсгөхөд нөлөөлнө. Монгол Улсын хувьд мөнгөний болоод сангийн бодлогын хамгийн муу, буруу хослопыг хэрэгжүүлж байна. Сангийн бодлогын бодит секторын өсөлтөнд чиглэсэн биш, хэрэглээнд чиглэсэн хэт тэлэлт нь үнийн түвшинд нөлөөлж улмаар мөнгөний хатуу бодлого явуулах арга хэмжээ авч энэ нь бодит секторын өсөлтөд сөргөөр нөлөөлдөг.⁸²

Дөрөв. Эдийн засгийн салбарын хууль, эрх зүйн орчинд гарсан зарим өөрчлөлт

- Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль** 2013 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан. Энэ хуульд банкны мөнгөн хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилго бүхий банкин дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалын эрх зүйн үндсийг тогтоож, хадгаламжийн даатгалын сангийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулсан.

Банкин дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалын үйл ажиллагааг эрхлэн явуулах тусгайлсан чиг үүрэг бүхий хуулийн этгээд /Хадгаламжийн даатгалын корпораци/-ийг үүсгэн байгуулж, банкнаас харилцах болон хадгаламжийн дансан дахь мөнгөн хөрөнгийг Хадгаламжийн даатгалын корпорацид даатгуулах, даатгалын тохиолдолд бий болоход хадгаламж эзэмшигчид даатгалын нөхөн төлөхтэй холбогдсон үйл ажиллагааг зохицуулснаараа ач холбогдолтой юм.

Энэ хууль батлагдсанаар санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, даатгалын тохиолдол бий болоход Хадгаламжийн корпораци хадгалмж эзэмшигчийн тухайн банкин дахь төрөг ба валютын нийт 20 сая хүртэл төгрөгийн хадгаламжийг нөхөн төлөхдөө тухайн банкны хадгаламж эзэмшигч бүрийг хамруулах, Банкны тухай хуулийн дагуу банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий банк хадгаламжийн даатганд хамрагдах зэргийг зохицуулахаар тусгажээ.

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай** хуулийн шинэчилсэн найруулга 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдөр батлагдсан. Уг хууль /2006/-ийг мөрдсөн хугацаанд Монгол Улсад банк, санхүүгийн тогтолцоо хөгжиж, гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэхийн хирээр түүний тогтвортой байдлыг хангах, хууль бус хөрөнгийг илрүүлэх, таслан зогсох, битүүмжлэх, хураах талаарх эрх зүйн орчны илүү боловсронгуй болгох зүй ёсны шаардлага гарсан. Өмнө нь НҮБ-ын холбогдох конвенц, Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын

⁸²"Төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангах асуудал буюу инфляцийн эсрэг хамтын ажиллагаа" СЯ-ны ТБГ, Монголбанкны МБСГ, ОУВС-ийн зөвлөх Jan-тай хамтарсан судалгааны тайлан.

байгууллагын зөвлөмжид манай эрх зүйн орчин нийцэхгүй байснаас олон улсын хяналт, шаардлагад өртөх үндсэн нөхцөл болж байв. Иймд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг энэ шаардлагад нийцүүлэн шинэчилснээр банк, санхүүгийн үйл ажиллагаанд учирч болох эрсдлийг хаах эрх зүйн үндэс бүрдсэн байна.

- Хөрөнгө оруулалтын тухай хууль** нь 2013 оны 10 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан. Энэ хуульд Монгол Улсын нутаг дэвсгэрт хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хөрөнгө оруулалтын эрх зүйн нийтлэг баталгааг тогтоох, хөрөнгө оруулалтыг дэмжих, татварын орчныг тогтвортжуулах, хөрөнгө оруулалтын талаар төрийн байгууллагын эрх хэмжээ, хөрөнгө оруулагчийн эрх, үүргийг тодорхойлох зохицуулалт оржээ.
- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг** 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан. Энэ хууль нь үнэт цаасны зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашигийг цогцоор нь хамгаалсан, уг зах зээлийн тогтвортой байдлыг хангасан эрх зүйн орчныг бурдүүлэх явдал байсан. Мөн түүнчлэн энэхүү хууль батлагдсанаар үндэсний болон гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгийн зах зээлд оролцох сонирхол нэмэгдэж, уг зах зээлийн эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмэр өссөн явдал юм.
- Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийг** 2013 оны 10 дугаар сарын 03-ны өдөр тус тус баталсан. Энэхүү хууль батлагдсанаар үнэт цаасны бүртгэл, хөрөнгө оруулагчдын эрх ашиг, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын эрх зүйн статус зэрэг харилцааг илүү нарийвчлан зохицуулснаараа ач холбогдолтой юм. Хөрөнгө оруулалтын сангийн тухай харилцааг хуульчлан зохицуулж өгснөөр санхүүгийн зах зээлийн зөв, тэнцвэртэй бүрэц бүрэлдэн тогтох боломж нээгдэж өгсөн төдийгүй цаашид хөрөнгө оруулалтын сангүүд үүсэх нь жижиг дунд үйлдвэр, компаниуд зөвхөн банкны зээл бус, харин хөрөнгө оруулалт хэлбэрээр санхүүжилт болгох замаар томорч, үйл ажиллагаагаа тэлэх боломжтой болно.

ХАВСРАЛТ.

ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЛАВЛАГАА

| № | Хууль | Зохицуулалт /холбогдох хуулийн заалтын хэсэгчлэн авав/ |
|---|-----------------------------|---|
| | | Үнэт цаасны зах зээл |
| 1 | Аудитын тухай 1997.05.01 | <p>4 дүгээр зүйл. Аудитын үйл ажиллагаа</p> <p>1. Аудитын үйл ажиллагаанд:</p> <p>7/ үнэт цаас гаргахтай холбогдсон эдийн засгийн тооцоо, судалгааны үндэслэлийг хянаж дүгнэлт гаргах;</p> <p>7 дугаар зүйл. Санхүүгийн тайлангаа баталгаажуулах байгууллага</p> <p>1. Дараахь аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангаа аудитын байгууллагаар заавал баталгаажуулна:</p> <p>1/ хөрөнгийн биржид бүртгэлтэй бүх төрлийн хувьцаат компани;</p> <p>2/ хөрөнгийн биржид бүртгүүлэх зөвшөөрөл хүсч буй компани;</p> <p>6/хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоо;</p> <p>7/ банк, санхүү, даатгалын байгууллага;</p> <p>8/ брокер, дилерийн үйл ажиллагаа явуулдаг үнэт цаасны компани болон хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхэлдэг компани;</p> |

| | | |
|---|---|--|
| 2 | Валютын зохицуулалтын тухай 1994.05.12 | 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт Энэ хуулийн зорилт нь валютын зохицуулалтын талаарх төрийн зохих байгууллагын бүрэн эрхийг тодорхойлж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд валютын гүйлгээ хийх, валютын гүйлгээнд хяналт тавих, Монгол Улсын үндэсний валютыг үнэгүйдлээс хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. |
| 3 | Иргэний хууль 2002.01.10 | 47 бүлэг Үнэт цаасны эргэлтээс үүсэх үүрэг 467-475 зүйл |
| 4 | Монгол Улсын Хөгжлийн банкны тухай 2011.02.10 | 7.1.Хөгжлийн банк дараах үйл ажиллагааг эрхэлнэ: 7.1.1.зээл олгох, авах; 7.1.2.зээлдэгчийн харилцах данстай холбоотой гадаад, дотоод төлбөр тооцоо хийх; 7.1.3.өөрийн нэрийн өмнөөс зээлийн баталгаа, батлан даалт гарах; 7.1.4.үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах; 7.1.5.гадаад валют худалдах, худалдан авах, хадгалуулах; 7.1.6.зээл худалдах, санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах; 7.1.7.хөрөнгө, өр төлбөрийн зүй зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа. 14 дүгээр зүйл.Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах 14.1.Энэ хуулийн 24.1-д заасан хязгаарлалтын хүрээнд хөрөнгийн болон мөнгөний зах зээл дээр арилжаалагдах үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах шийдвэрийг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл болон эдийн засгийн хөгжлийн, санхүү, төсвийн асуудал эрхэлсан Засгийн газрын гишүүний саналыг тус тус үндэслэн Хувь нийлүүлэгчдийн хурал гаргана. |
| 5 | Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай 2005.11.17 | 3 дугаар зүйл. Хуулийн үйлчилэх хүрээ 3.1. Энэ хуульд заасан санхүүгийн үйлчилгээнд дараах үйл ажиллагаа хамаарна: 3.1.1. банк бус санхүүгийн байгууллагын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа; 3.1.2. үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үйл ажиллагаа; 3.1.3. даатгачийн Даатгалын тухай хуульд заасан үйл ажиллагаа; 3.1.4. даатгалын төлөөлөгч, зуучлагч, хохирол үнэлгэгчийн Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд заасан үйл ажиллагаа; 3.1.5. хоршооны Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд заасан хадгаламж, зээлийн үйл ажиллагаа; 3.1.6.хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа; 3.1.7. Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд заасан үйл ажиллагаа; 3.1.8.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд заасан даатгалын үйл ажиллагаа; 3.1.9. хуульд заасан санхүүгийн бусад үйл ажиллагаа. |

| | | |
|---|--|--|
| 6 | Үнэт цаасны зах зээлийн тухай 2013.05.24 | <p>5 дугаар зүйл. Үнэт цаас</p> <p>5.1. Энэ хуулийн зохицуулалтад хамрагдах үнэт цаасанд дараах санхүүгийн хэрэгсэл хамаарна:</p> <ul style="list-style-type: none"> 5.1.1. хувьцаат компанийн хувьцаа /цаашид “хувьцаа” гэх/; 5.1.2. компанийн ерийн хэрэгсэл; 5.1.3. Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан ерийн хэрэгсэл; 5.1.4. хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, нэгж эрх; 5.1.5. хадгаламжийн бичиг; 5.1.6. хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас; 5.1.7. үнэт цаас гаргагчаас хөрөнгө оруулагчид санал болгож байгаа тодорхой тооны хувьцаа болон ерийн хэрэгслийг тодорхой хугацааны дотор тохиролцсон үнээр захиалах эрх /варрант/; 5.1.8. энэ хуульд заасан үүсмэл санхүүгийн хэрэгсэл; 5.1.9. энэ хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаас гэж тогтоосон бусад санхүүгийн хэрэгсэл. <p>5.2. Хуульд өөрөөр заагаагүй бол дор дурдсан санхүүгийн хэрэгсэл энэ хуулийн зохицуулалтад хамаарахгүй:</p> <ul style="list-style-type: none"> 5.2.1. хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа; 5.2.2. зохицуулалттай зах зээлд арилжихаар гаргаж байгаа нэг жил хүртэлх хугацаатай бусад санхүүгийн хэрэгсэл; 5.2.3. шилжүүлгийн болон энгийн вексель; 5.2.4. банкнаас гаргасан хадгаламжийн сертификат; 5.2.5. Банкны тухай хуулийн 15.2-т заасны дагуу банкнаас мөнгөний зах зээлд арилжихаар гаргаж байгаа нэг жил хүртэлх хугацаатай бусад санхүүгийн хэрэгсэл. <p>5.3. Энэ хуулийн 5.2.4-т заасан санхүүгийн хэрэгсэл нь хадгаламжийн бичигт хамаарахгүй.</p> |
| 7 | Хөрөнгө оруулалтын сангийн тухай 2013.10.03 | <p>3 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн үйлчлэх хүрээ</p> <p>3.1. Энэ хуулиар хөрөнгө оруулалтын санд тусгай зөвшөөрөл олгох, сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах, сангийн хөрөнгөөр үйл ажиллагаа эрхлэх болон сангийн хөрөнгийг хадгалах, бүртгэх, хөрөнгө оруулагчийг мэдээллээр хангах, хөрөнгө оруулалтын санд үйлчилгээ үзүүлэх үнэт цаасны зах зээлийн зохицуулалт бүхий хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.</p> <p>3.2. Тусгай хуулиар зохицуулагдсан сан, түүний хөрөнгөөр хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон харилцаа энэ хуульд хамаарахгүй.</p> <p>3.3. Банк, банк бус санхүүгийн байгууллага, даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогч, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.12, 24.1.13-т зааснаас бусад зохицуулалттай хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийхтэй холбогдсон харилцаа энэ хуульд хамаарахгүй.</p> <p>3.4. Банк нийтээс төвлөрүүлсэн хадгаламжийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийхтэй холбогдсон харилцааг Банкны тухай хуулиар зохицуулна.</p> |
| 8 | Хөрөнгө оруулалтын тухай 2013.10.03 | <p>5 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын хэлбэр</p> <p>5.1. Хөрөнгө оруулалтыг Монгол Улсад дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> 5.1.1. хөрөнгө оруулагч дангаараа болон бусад хөрөнгө оруулагчтай хамтран аж ахуйн нэгж байгуулах; 5.1.2. хөрөнгө оруулагч хувьцаа, ерийн бичиг, бусад төрлийн үнэт цаасыг худалдан авах; 5.1.3. компанийг нэгтгэх, нийлүүлэх замаар хөрөнгө оруулалт хийх; 5.1.4. концесс, бүтээгдэхүүн хуваах, маркетинг, менежментийн болон бусад гэрээ байгуулах; 5.1.5. санхүүгийн түрээс /лизинг/-ийн болон франчайзийн хэлбэрийн хөрөнгө оруулалт хийх; 5.1.6. хуулиар хориглоогүй бусад хөрөнгө оруулалтын хэлбэр. |

| | | |
|----------------------|---|--|
| 9 | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль 2010.04.23 | 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, түүнд хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. |
| Банкны салбар | | |
| 10 | Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай 1995.10.31 | 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт Энэ хуулийн зорилт нь иргэн, хуулийн этгээдээс банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдэд мөнгөн хөрөнгө хадгалуулах, хоорондын төлбөр тооцоогоо банк, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээр дамжуулан гүйцэтгэх, банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл авах, түүний эргүүлэн төлөх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. |
| 11 | Банкин дахь мөнгөн хадгаламжинд даатгалын тухай 2013.01.10 | 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь банкны мөнгөн хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилго бүхий банкин дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалын эрх зүйн үндсийг тогтоож, хадгаламжийн даатгалын сангийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. |
| 12 | Банкны тухай хууль 2010.01.28 | 6 дугаар зүйл. Банкны эрхлэх үйл ажиллагаа 6.1.Банк Монголбанкны тусгай зөвшөөрөлтэйгээр дараахь үйл ажиллагаа эрхэлнэ: 6.1.1.мөнгөн хадгаламж; 6.1.2.зээл; 6.1.3.төлбөр тооцооны үйлчилгээ; 6.1.4.өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах; 6.1.5.гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах; 6.1.6.үнэт металл, эрдэнийн чулуу худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах; 6.1.7.үнэт зүйл хадгалах; 6.1.8.гадаад төлбөр тооцоо хийх; 6.1.9.үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах; 6.1.10.санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа; 6.1.11.зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах; 6.1.12.хууль тогтоомжоор хориглоогүй бөгөөд Монголбанкнаас зөвшөөрсөн санхүүгийн бусад ажил, үйлчилгээ. 6.2.Банк, түүний хараат болон охин компани Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэйгээр дараахь үйл ажиллагаа эрхэлнэ: 6.2.1.санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх; 6.2.2.итгэлцлийн үйлчилгээ; 6.2.3.даатгалын зуучлагч; 6.2.4.андеррайтерын үйлчилгээ; 6.2.5.кастодиан; 6.2.6.факторингийн үйлчилгээ; 6.2.7.харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил, үйлчилгээ. 15 дугаар зүйл. Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах 15.1.Энэ хуулийн 17.4-т заасан хязгаарлалтын хүрээнд хөрөнгийн зах зээл дээр арилжаалагдах үнэт цаас гаргах, барьцаалах, худалдах, худалдан авахтай холбогдсон банкны үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна. 15.2.Банк мөнгөнийн зах зээл дээр арилжаалагдах нэг жил хүртэлх хугацаатай үнэт цаасыг Монголбанкны зөвшөөрлөөр гаргах буюу худалдаж, худалдан авч, барьцаалж болох бөгөөд энэ нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасанд хамаарахгүй. |

| | | |
|----|--|--|
| 13 | Векселийн тухай 1995.11.02 | 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт Энэ хуулийн зорилт нь иргэн, хуулийн этгээд болон тэдгээрийн хооронд хийх төлбөр тооцоонд векселийг хэрэглэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино. |
| 14 | Иргэний тухай хууль 2002.01.10 | 44 булэг Зээл тооцооны үүрэг 445-466 зүйл Банк төлбөр тооцоо |
| 15 | Монгол Улсын Хөгжлийн банкны тухай 2011.02.10 | 7.1.Хөгжлийн банк дараах үйл ажиллагааг эрхэлнэ: 7.1.1.зээл олгох, авах; 7.1.2.зээлдэгчийн харилцах данстай холбоотой гадаад, дотоод төлбөр тооцоо хийх; 7.1.3.өөрийн нэрийн өмнөөс зээлийн баталгаа, батлан даалт гарах; 7.1.4.үнэт цаас гарах, худалдах, худалдан авах; 7.1.5.гадаад валют худалдах, худалдан авах, хадгалуулах; 7.1.6.зээл худалдах, санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах; 7.1.7.хөрөнгө, өр төлбөрийн зүй зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа. |
| 16 | Төв банк /Монгол банк/-ны тухай 1996.09.03 | 5 дугаар зүйл. Монголбанкны үйл ажиллагааны чиглэл Монголбанк энэ хуульд заасан өөрийн зорилтыг биелүүлэхийн тулд дараах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлнэ: 1/ мөнгөн тэмдэгт гүйлгээнд гарах; 2/мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх; 3/ Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх; 4/ банкны үйл ажиллагаанд хяналт тавих; 5/ банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах; 6/ гадаад валютын улсын нөөцийг эзэмшиж, удирдах. |
| 17 | Шилэн дансны тухай 2014.07.01 | 6 дугаар зүйл. Шилэн дансны мэдээлэл 6.9.Арван сая төгрөгөөс дээш үнийн дунгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжилж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй. |
| 18 | Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай 2010.10.11 | 4-р булаг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл, мөнгөний бодлого, төсөв, түүний гүйцэтгэлийг хэлэлцэх журам 25-р Үндсэн чиглэл, мөнгөний бодлого, төсөв хэлэлцэх |

| Бичил санхүүгийн зах зээл | | |
|---------------------------|---|---|
| 19 | Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай 2002.12.12 | <p>7 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа</p> <p>7.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа гэж дараахь үйл ажиллагааг ойлгоно:</p> <ul style="list-style-type: none"> 7.1.1. зээл; 7.1.2. факторингийн үйлчилгээ; 7.1.3. санхүүгийн түрээ; 7.1.4. төлбөрийн баталгаа гаргах; 7.1.5. төлбөр тооцооны хэрэгсэл гаргах; 7.1.6. цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвуулгын үйлчилгээ; 7.1.7. гадаад валютын арилжaa; 7.1.8. итгэлцлийн үйлчилгээ; 7.1.9. богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх; 7.1.10. хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх. 7.1.11. үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа. |
| 20 | Хадгаламж зээлийн хоршооны тухай 2011.10.27 | <p>16 дугаар зүйл. Хадгаламж, зээлийн хоршооны хадгаламжийн үйл ажиллагаа</p> <p>16.1. Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хадгаламж, зээлийн хоршоо нь бичгээр байгуулсан гэрээний үндсэн дээр зөвхөн гишүүдийнхээ мөнгөн хөрөнгийг хадгалж болно.</p> <p>16.2. Хадгаламжийн үйл ажиллагааны бодлогыг хадгаламж, зээлийн хоршооны бүх гишүүдийн хурлаас батална.</p> <p>16.3. Хадгаламж хэлбэрээр татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө нь тухайн хадгаламж, зээлийн хоршооны өөрийн хөрөнгөд хамаарахгүй бөгөөд уг хөрөнгийг зөвхөн зээлийн болон Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн бусад ажил, үйлчилгээний эх үүсвэр болгон ашиглахаас бусад зориулалтаар ашиглахыг хориглоно.</p> <p>16.4. Гишүүний хадгаламжийг барьцаалж, түүнд зээл олгож болно.</p> <p>16.5. Хадгаламжийг хамтран эзэмшиж болох бөгөөд хамтран эзэмшигч нь хадгаламж, зээлийн хоршооны гишүүн байх эсэх асуудлыг тухайн хадгаламж, зээлийн хоршооны дүрмээр зохицуулна.</p> <p>16.6. Нэг гишүүнээс авч болох хадгаламжийн хэмжээнд Хороо хязгаарлалт тогтоож болно.</p> <p>16.7. Хадгаламж, зээлийн хоршоо гишүүдийнхээ хадгаламжийн баталгааг хангах үүрэгтэй.</p> |



АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- “Эдийн засгийн ухаан Макро экономикс” Н.Грегори Мэнкью УБ, 2009 он;
- “Макро эдийн засгийн төрийн зохицуулалт, санхүү-мөнгөний бодлого” Д.Лувсанцэрэн УБ, 2008 он;
- “Төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангах асуудал буюу инфляцийн эсрэг хамтын ажиллагаа” Сангийн яамны Төсвийн бодлогын газар нь Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газар болон ОУВС-ийн зөвлөх Jan-тай хамтарсан судалгааны тайлан, www.iltod.gov.mn;
- “Монголын эдийн засгийн эмзэг байдлын үнэлгээ” Д.Ган-Очир, УБ, 2012 он;
- “Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын хандлага ” Ч.Хашчулуун УБ, 2012 он;
- “Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн үр өгөөжийг дээшлүүлэх нь” судалгааны тайлан, Т.Нарантуяа, Д.Баярмаа, М.Сарантуяа , ШУТИС, КтМС УБ, 2012 он;
- www.legalinfo.mn
- www.nso.mn
- www.1212.mn
- www.frc.mn

